

БАТЛАВ.
АЖУЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Б.ДАШПҮРЭВ

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН АВИЛГААС СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ ОЛГОХ
СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

2025 оны 09 р сарын 03 -ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Сургалтын зорилго

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн төлөөллүүдэд зориулсан "Авилгаас урьдчилан сэргийлэх" сургалтын зорилгыг дор дурдсан заримаар тодорхойлов. Үүнд:

1. Монгол Улсын "2024- 2030 онд Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр", хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний ач холбогдолыг танилцуулах;
2. ОУИТБС-ын 2023 оны стандартын шинэ шаардлага, ач холбогдолыг танилцуулах;
3. Монгол Улсын ОУИТБС-ын 2025 оны ажлын төлөвлөгөөний 17.2- д заасан "Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд авилгаас сэргийлэх дотоод дүрэмтэй болсон байх" гэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох;
4. Оролцогч талуудын байр суурийг сонсох, хэлэлцэх, санал солилцох, дэд хэсэг байгуулах;

Хоёр. Сургалтын дэг, зохион байгуулалт

1. Сургалтыг 9-р сарын 19 өдөр, 10-р сарын 15 өдөр, 11-р сарын 05 өдрүүдэд 3 удаа зохион байгуулна.
2. Сургалтыг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон удирдан явуулна.
3. Сургалтад оролцох төлөөллийг цахимаар бүртгэж, сургалтын материалыг оролцогч нарт сургалт эхлэхээс 1 доошгүй хоногийн өмнө цахимаар урьдчилан хүргүүлж, материалтай урьдчилан танилцах, санал боловсруулах, асуулт тавих боломжоор хангасан байна.
4. Сургалтын танилцуулгыг илтгэгч нар илтгэлээ 20- 30 минутад багтаан тавьж, илтгэл дундуур тавьсан асуултад хариулна.

Гурав. Хүлээгдэх үр дүн

Сургалтыг зохион байгуулснаар дараах үр дүн хүлээгдэж байна. Үүнд:

1. Монгол Улсын "Авилгаас урьдчилан сэргийлэх" талаар хэрэгжүүлж байгаа болон төлөвлөж байгаа үйл ажиллагааны талаар сүүлийн үеийн мэдлэг, мэдээлэлтэй болно.
2. Авилгаас сэргийлэх дотоод дүрмийн талаар заавар авч, мэдээлэл авсны үндсэн дээр цаашид энэ чиглэлээр арга хэмжээ авах боломтой болно.
3. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн төлөөллийн "Авилгаас урьдчилан сэргийлэх" чиглэлээр дэд хэсэг байгуулах боломжтой болж, хамтран ажиллах үндэс тавигдана.

Дөрөв. Шийдвэр

Сургалтаас гарах шийдвэр нь тэмдэглэл хэлбэртэй байх ба сургалтад оролцсон төлөөлөлд уншиж танилцуулсны үндсэн дээр баталгаажуулна.

Танилцсан:

АҮЭБЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын
хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Т.Амартүвшин

Боловсруулсан:

ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч

Ш.Цолмон

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН АВИЛГААС СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ ОЛГОХ
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Хугацаа	Агуулга
09:30-10:00	Оролцогчдын бүртгэл, Кофе цай
10:00-10:15	Нээлт: - Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв
10:15-10:35	Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр, хэрэгжилтийн байдал, цаашид анхаарах асуудал: - Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн Ажлын албаны дарга С.Дуламсүрэн
10:35-10:55	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн "Нийтийн баялгийн менежментэд шударга байдлыг бэхжүүлэх нь" төслийн танилцуулга: - Төслийн зохицуулагч Р.Ариунбилэг
10:55-11:15	Монгол Улсад ОУИТБС хэрэгжиж байгаа нь, 2023 оны стандартын шинэ шаардлага: - ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон
11:15-11:25	Цайны завсарлага
11:55-12:15	Авилгатай тэмцэх асуудал ба Компанийн оролцоо: - Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэтуяа
12:15-12:45	"Хуулийн этгээдийн авилгаас сэргийлэх дүрэм"- төслийн танилцуулга: - ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон
12:45-13:00	Сургалтын дүгнэлт, дэд хэсэг байгуулах, тэмдэглэл батлах: - АҮЭБЯ-ны санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Амартүвшин
13:00	Үдийн хоол